



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/210

Улаанбаатар хот

Хяналтын улсын байцаагчийн эрх,
албаны болон хувийн дугаар олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолын 2 дахь заалт, тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-ын 1.2, 6.1 дэх заалт, дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг, олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын байцаагчийн эрх олгох албан хаагчийн нэр, албаны болон хувийн дугаарыг хавсралтаар баталсугай.

2. Эрх олгогдсон хяналтын улсын байцаагчид Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолын хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу үнэмлэх, тэмдэг олгох, холбогдох зардлыг гаргахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Зэндмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД *C. Чинзориг* С.ЧИНЗОРИГ



141223919

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06
дугаар сарын 13 -ны өдрийн А/210
дугаар тушаалын хавсралт

Улсын байцаагчийн эрх олгох албан хаагчийн овог нэр,
албаны болон хувийн дугаар

№	Овог, нэр	Албан тушаал	Албаны болон хувийн дугаар
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар			
1.	Батсүрэн Ганпүрэв	Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч	10-13-05/206
2.	Шинэбаяр Шижирбат	Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч	10-13-05/207